



МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/167

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн нэгдсэн бодлогын газар /Л.Балчинлуvsан/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү аргачлалыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД



Ч.ХҮРЭЛБААТАР

УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага нь (цаашид "холбогдох байгууллага" гэх) Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналаа нэгтгэн боловсруулах болон Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "ЭЗХЯ" гэх) нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулахад энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Эрх бүхий албан тушаалтан нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актад үндэслэнэ.

1.3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг энэхүү аргачлалын нэгдүгээр хавсралтад заасан загварын дагуу боловсруулна.

1.4. Энэ аргачлалд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. "үндэсний үр дүн" гэж улс оршин байх тулгуур үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;

1.4.2. "салбарын үр дүн" гэж үндэсний үр дүнг хангах тухайн салбарын тулгуур үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;

1.4.3. "төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн" гэж салбарын үр дүнг хангах төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний үндсэн үзүүлэлтэд гарах эерэг өөрчлөлтийг;

1.4.4. "хөтөлбөрийн үр дүн" гэж төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг хангах хөтөлбөр хэрэгжсэнээр бий болох эерэг өөрчлөлтийг;

1.4.5. "хөтөлбөр" гэж Төсвийн тухай хуулийн 4.1.16-д тодорхойлсныг;

1.4.6. "үндсэн үйл ажиллагаа" гэж төрийн байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчийн мандатыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай багц арга хэмжээг;

1.4.7. "төсөл" гэж хөтөлбөрийн үр дүн гарахад хувь нэмэр оруулахаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт эсвэл нэг удаагийн багц арга хэмжээг;

1.4.8. "арга хэмжээ" гэж Төсвийн тухай хуулийн 4.1.17-д тодорхойлсныг.

Хоёр. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах дараалал

2.1. Холбогдох байгууллага нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд хариуцсан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хэсэг (холбогдох газар, хэлтсийн оролцоог хангана)-ийг байгуулж, ажлын төлөвлөгөөг төсвийн хамт Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулна.

2.2. Ажлын хэсэг нь холбогдох нөөцийн бэлэн байдлыг хангана.

2.2.1. Хүний нөөц;

2.2.2. Мэдээллийн нөөц;

2.2.3. Санхүүгийн нөөц.

2.3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд холбогдох байгууллага нь нөхцөл байдлын дүн шинжилгээ хийнэ.

2.4. Холбогдох байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулж, ЭЗХЯ-нд ирүүлнэ.

2.5. ЭЗХЯ нь үндэсний хөгжлийн хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, бусад төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн хуулийн этгээдийг оролцуулан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулна.

2.6. ЭЗХЯ нь холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагад танилцуулж, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал авна.

2.7. ЭЗХЯ нь холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналын үндэслэлийг хянаж төслийн эцсийн хувилбарыг боловсруулна.

2.8. ЭЗХЯ нь холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагуудад мэдээлнэ.

2.9. ЭЗХЯ нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг хуульд заасан хугацаанд багтаан Засгийн газарт танилцуулна.

2.10. Ажлын хэсэг нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмж боловсруулж оролцогч талуудад нэгдсэн байдлаар хүргүүлнэ.

Гурав. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах цаглавар

3.1. Ажлын хэсэг нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг энэхүү аргачлалын хоёрдугаар хавсралтад заасан цаглаварын дагуу боловсруулна.

3.2. Ажлын хэсэг нь өмнөх оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмжтэй танилцаж төлөвлөгөө боловсруулахдаа тусгана.

Дөрөв. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх

4.1. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг нь нийт улс орны хэмжээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийнэ. Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх хүрээнд дараах мэдээллийг цуглуулна.

4.1.1. Өмнөх жилийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний урьдчилсан гүйцэтгэл;

4.1.2. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн суурь мэдээлэл;

4.1.3. Олон улс, хөрш орнуудын нийгэм эдийн засгийн төлөв байдлын таамаглал;

4.1.4. Улсын мөнгөний бодлогын суурь мэдээлэл;

4.1.5. Дотоод харилцааны нөхцөл байдал, иргэдийн харилцааны хандлагын өөрчлөлтийн таамаглал;

4.1.6. Иргэдийн амьжиргаа, ажил эрхлэлтийн хандлагын өөрчлөлтийн таамаглал;

4.1.7. Ирэх жилийн салбарын ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн хандлагын өөрчлөлтийн таамаглал.

4.2. ЭЗХЯ нь энэхүү аргачлалын 4.1 дэх хэсэгт заасан мэдээ, мэдээлэл, өгөгдөлд дүн шинжилгээ хийж, ирэх жилийн хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлд нөлөөлөх шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж, үнэлэн, эрсдэлийг удирдах арга замыг тодорхойлсон эрсдэлийн суурь судалгааг боловсруулан, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний танилцуулгад хавсаргана.

4.3. ЭЗХЯ нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн жилийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлийг дараах үзүүлэлтийг үндэслэн тодорхойлно.

4.3.1. Нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн;

4.3.2. Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын хүрсэн үр дүн;

4.3.3. Дунд хугацааны төлөвлөлтийн хүрсэн үр дүн.

4.4. Холбогдох байгууллага нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээг дараах мэдээлэлд тулгуурлан хийнэ.

4.4.1. Мандатын шинжилгээ;

4.4.2. Дотоод, гадаад орчны шинжилгээ;

4.4.3. Шаардлагатай тохиолдолд Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон хөтөлбөрийн үр дүн болон хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх арга замыг шинээр тодорхойлох, орчны шинжилгээгээр тогтоогдсон сул тал, эрсдэлийг арилгах төлөвлөгөө;

4.4.4. Стратеги төлөвлөгөөний үр дүнгийн шинжилгээ;

4.4.5. Жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнгийн шинжилгээ.

Тав. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах санал авах

5.1. ЭЗХЯ нь холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах саналыг энэхүү аргачлалын гуравдугаар хавсралтын нэгдүгээр хүснэгтийн дагуу авах бөгөөд санал авахдаа дараах материалыг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

5.1.1. Холбогдох байгууллагаас санал авах маягт, маягтыг бөглөх заавар (удирдамж);

5.1.2. Үндэсний болон салбарын үр дүн, үр дүнгийн үзүүлэлтүүд.

5.2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах санал нь дараах шаардлагыг хангасан байна.

5.2.1. Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байх;

5.2.2. Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон байх;

5.2.3. Хариуцах эзэнтэй байх;

5.2.4. Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан байх;

5.2.5. Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний саналыг хөтөлбөр тус бүрээр ач холбогдлоор нь эрэмбэлж, өртгийн тооцоог үндэслэлтэйгээр хийсэн байх.

5.4. Холбогдох байгууллага нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах санал өгөхдөө дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон тусгагдаагүй гэсэн хоёр бүлгээр ялгаж ирүүлнэ.

5.5. Дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусгагдаагүй үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний хувьд тухайн жилийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд зайлшгүй тусгах шаардлагатай гэдгийг үндэслэл, тооцоо судалгааны хамт ирүүлнэ.

Зургаа. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх үр дүнг төлөвлөх

6.1. Тухайн жилийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх үр дүн, тэдгээрийн үзүүлэлтүүдийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг болон нөхцөл байдлын дүн шинжилгээ, холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналд үндэслэн ЭЗХЯ тодорхойлно.

6.2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх үр дүнг Үндэсний, салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн, хөтөлбөрийн гэсэн дөрвөн түвшнээр ялгаж хооронд нь уялдуулан төлөвлөнө.

6.3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх Үндэсний, салбарын, Төсвийн ерөнхийлөн захирагчийн, хөтөлбөрийн үр дүнг кодолно.

6.4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх Үндэсний үр дүнг энэхүү аргачлалын нэгдүгээр хавсралтын нэгдүгээр хүснэгтийн дагуу дараах байдлаар төлөвлөнө.

6.4.1. “Үндэсний үр дүн” баганад Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилгод үндэслэн Үндэсний үр дүнг тодорхойлж бичнэ.

6.4.2. “Бодлогын үндэслэл” баганад Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилгын дугаарыг бичнэ.

6.4.3. “Шалгуур үзүүлэлт”, “Хэмжих нэгж” баганад Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үндэслэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж бичнэ.

6.4.4. “Суурь түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, өмнөх оны хүрсэн түвшинд (тухайн жилд хүрсэн түвшин тодорхойлогдоогүй тохиолдолд хамгийн сүүлд хийгдсэн бодлогын үнэлгээний хүрээнд тодорхойлсон хүрсэн түвшин) үндэслэн суурь түвшнийг тодорхойлж бичнэ.

6.4.5. “Зорилтот түвшин” баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшин, тухайн жилд хүрэхээр төлөвлөсөн түвшнийг шинжлэн зорилтот түвшнийг тодорхойлж бичнэ.

6.5. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх Салбарын үр дүнг энэхүү аргачлалын нэгдүгээр хавсралтын хоёрдугаар хүснэгтийн дагуу дараах байдлаар төлөвлөнө.

6.5.1. "Салбарын үр дүн" баганад Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтод үндэслэн Салбарын үр дүнг тодорхойлж бичнэ.

6.5.2. "Бодлогын үндэслэл" баганад Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтын дугаарыг бичнэ.

6.5.3. "Шалгуур үзүүлэлт", "Хэмжих нэгж" баганад Урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үндэслэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж бичнэ.

6.5.4. "Суурь түвшин" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, өмнөх оны хүрсэн түвшинд (тухайн жилд хүрсэн түвшин тодорхойлогдоогүй тохиолдолд хамгийн сүүлд хийгдсэн бодлогын үнэлгээний хүрээнд тодорхойлсон хүрсэн түвшин) үндэслэн суурь түвшнийг тодорхойлж бичнэ.

6.5.5. "Зорилтот түвшин" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшин, тухайн жилд хүрэхээр төлөвлөсөн түвшнийг шинжлэн зорилтот түвшнийг тодорхойлж бичнэ.

6.5.6. "Тэргүүлэх чиглэл" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүнд тодорхойлсон тэргүүлэх чиглэлийг хуулж бичнэ.

6.6. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг энэхүү аргачлалын нэгдүгээр хавсралтын гуравдугаар хүснэгтийн дагуу дараах байдлаар төлөвлөнө.

6.6.1. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн" баганад Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтод үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнг тодорхойлж бичнэ.

6.6.2. "Бодлогын үндэслэл" баганад Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтын дугаарыг бичнэ.

6.6.3. "Шалгуур үзүүлэлт", "Хэмжих нэгж" баганад Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үндэслэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж бичнэ.

6.6.4. "Суурь түвшин" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, өмнөх оны хүрсэн түвшинд (тухайн жилд хүрсэн түвшин тодорхойлогдоогүй тохиолдолд хамгийн сүүлд хийгдсэн бодлогын үнэлгээний хүрээнд тодорхойлсон хүрсэн түвшин) үндэслэн суурь түвшнийг тодорхойлж бичнэ.

6.6.5. "Зорилтот түвшин" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшин, тухайн жилд хүрэхээр төлөвлөсөн түвшнийг шинжлэн зорилтот түвшнийг тодорхойлж бичнэ.

6.6.6. "Арга зам" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүнд тодорхойлсон арга замыг хуулж бичнэ.

6.7. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хүрэх Хөтөлбөрийн үр дүнг энэхүү аргачлалын нэгдүгээр хавсралтын дөрөвдүгээр хүснэгтийн дагуу дараах байдлаар төлөвлөнө.

6.7.1. "Хөтөлбөрийн үр дүн" баганад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтод үндэслэн Хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж бичнэ.

6.7.2. "Бодлогын үндэслэл" баганад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтын дугаарыг бичнэ.

6.7.3. "Шалгуур үзүүлэлт", "Хэмжих нэгж" баганад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд үндэслэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж бичнэ.

6.7.4. "Суурь түвшин" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, өмнөх оны хүрсэн түвшинд (тухайн жилд хүрсэн түвшин тодорхойлогдоогүй тохиолдолд хамгийн сүүлд хийгдсэн бодлогын үнэлгээний хүрээнд тодорхойлсон хүрсэн түвшин) үндэслэн суурь түвшнийг тодорхойлж бичнэ.

6.7.5. "Зорилтот түвшин" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, суурь түвшин, тухайн жилд хүрэхээр төлөвлөсөн түвшнийг шинжлэн зорилтот түвшнийг тодорхойлж бичнэ.

6.7.6. "Арга зам" баганад нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүнд тодорхойлсон арга замыг хуулж бичнэ.

Долоо. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг төлөвлөх

7.1. Тухайн жилийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгагдах үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ, тэдгээрийн үзүүлэлтүүдийг холбогдох байгууллагын санал болон нөхцөл байдлын дүн шинжилгээнд (макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, гадаад өрийн зохистой харьцаа, төсвийн хүрээний мэдэгдэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (цаашид ЗГҮАХХАХТ гэх)-г үндэслэн ЭЗХЯ эцэслэн тодорхойлно.

7.2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөрийн үр дүн тус бүрээр төлөвлөнө.

7.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний хөтөлбөрийн үр дүн, энэхүү үр дүнгийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг кодолно.

7.4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг энэхүү аргачлалын нэгдүгээр хавсралтын тавдугаар хүснэгтийн дагуу төлөвлөнө.

7.5. Тавдугаар хүснэгтийн "Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ" баганад тухайн жилийн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгагдахаар дэмжигдсэн үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг ЗГҮАХХАХТ-өөс нөхөж бичнэ.

7.6. Тавдугаар хүснэгтийн "Бодлогын үндэслэл", "Шалгуур үзүүлэлт", "Хэмжих нэгж" баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний холбогдох хэсгийг нөхөж бичнэ.

7.7. Тавдугаар хүснэгтийн "Суурь түвшин" баганад холбогдох байгууллагаас ирүүлсэн үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний суурь түвшнийг нөхөж бичнэ.

7.8. Тавдугаар хүснэгтийн "Зорилтот түвшин" баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний зорилтот түвшний талаарх холбогдох байгууллагын санал болон нөхцөл байдлын дүн шинжилгээний үр дүн, өмнөх оны гүйцэтгэл, ЗГҮАХХАХТ-ний тухайн жилд хүрэхээр төлөвлөсөн түвшин зэргийг шинжлэн тодорхойлно.

7.9. Тавдугаар хүснэгтийн "Шаардлагатай хөрөнгийн хэмжээ" баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн талаарх холбогдох

байгууллагын санал болон ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан шаардагдах хөрөнгийн хэмжээ, Монгол банкны ханшны өсөлт бууралтын таамаглал, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, хэлэлцэн тохирсон зээлийн болон бусад санхүүжилтийн боломжийг харгалзан тооцоолно.

7.10. Тавдугаар хүснэгтийн "Санхүүжилтийн эх үүсвэр" баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийн талаарх холбогдох байгууллагын саналд үндэслэн тодорхойлж бичнэ.

7.11. Тавдугаар хүснэгтийн "Хариуцагч" баганад үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хариуцах Төсвийн ерөнхийлөн захирагч болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг (Харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч) бичнэ.

Найм. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох

8.1 Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнд хамаарах үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн хэмжээг энэхүү аргачлалын дөрөвдүгээр хавсралтын дагуу бөглөнө.

8.2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнд хамаарах үндсэн үйл ажиллагааг ерөнхий удирдлагын, үндсэн, дэмжих болон худалдан авалтын үйл ажиллагаа хэмээн ангилж, холбогдох зааврын дагуу зардлуудыг төсөвлөнө.

8.3. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнд хамаарах төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн хэмжээг ЗГҮАХХАХТ-нд туссан тухайн төслийн тухайн жилд хуваарилахаар заасан төсвөөр тодорхойлно.

8.4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн үр дүнд хамаарах арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн хэмжээг ЗГҮАХХАХТ-нд туссан арга хэмжээний тухайн жилд хуваарилахаар заасан төсвөөр тодорхойлно.

8.5. Хөтөлбөрийн нийт зардлыг хөтөлбөрийн үр дүнгүүдийн үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний зардлуудын нийлбэрээр тодорхойлно.

8.6. Үр дүнгийн санхүүжилтийг хийх боломжтой эх үүсвэрийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, гадаад өрийн зохистой харьцаа, гадаад улс орнуудын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын ирэх жилүүдийн таамаглалд үндэслэн тодорхойлно.

8.7. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрт ЗГҮАХХАХТ-нд тооцсон санхүүжилтийн дүн, дотоодын эдийн засгийн хөгжлийн нөхцөл байдал болон үнийн таамаглал, голлох валютын ханшийн таамаглалд тулгуурлан тохируулга хийнэ.

Ес. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн талаар Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдээлэл хүргүүлэх, санал авах

9.1. ЭЗХЯ нь холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллага тус бүрээр энэхүү аргачлалын тавдугаар хавсралтын нэгдүгээр хүснэгтийн дагуу танилцуулна.

9.2. ЭЗХЯ нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд холбогдох байгууллагаас энэхүү аргачлалын гуравдугаар хавсралтын хоёрдугаар хүснэгтийн дагуу санал авна.

9.3. ЭЗХЯ нь холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллага тус бүрээр энэхүү аргачлалын тавдугаар хавсралтын хоёрдугаар хүснэгтийн дагуу танилцуулна.

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/167 тушаалын хоёрдугаар хавсралт

УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

Нэг. Тухайн жилд хүрэх үр дүн:

Хүснэгт 1. Үндэсний үр дүн /Тухайн жилд хүрэх үр дүн/

Код	Бодлогын үндэслэл	Үндэсний үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин
Y1*						

Тайлбар: * Y1 – Үндэсний үр дүн 1. Үндэсний үр дүнгийн дугаараар Y үсгийн дараах тоо өөрчлөгдөнө.

Хүснэгт 2. Салбарын үр дүн /Тухайн жилд хүрэх үр дүн/

Код	Бодлогын үндэслэл	Салбарын үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Тэргүүлэх чиглэл
Y1C1*							

Тайлбар: * Y1C1 – Үндэсний үр дүн 1-д хамаарах Салбарын үр дүн 1. Салбарын үр дүнгийн дугаараар C үсгийн дараах тоо өөрчлөгдөнө.

Хүснэгт 3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн /Тухайн жилд хүрэх үр дүн/

Код	Бодлогын үндэслэл	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Арга зам
Y1C1T1*							

Тайлбар: * Y1C1T1 – Үндэсний үр дүн 1-д хамаарах Салбарын үр дүн 1-ийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний асуудлын 1 дэх үр дүн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн дугаараар T үсгийн дараах тоо өөрчлөгдөнө.

Хүснэгт 4. Хөтөлбөрийн үр дүн /Тухайн жилд хүрэх үр дүн/

Код	Бодлогын үндэслэл	Хөтөлбөрийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Арга зам
Y1C1T1X1*							

Тайлбар: * Y1C1T1X1 – Үндэсний үр дүн 1-д хамаарах Салбарын үр дүн 1-ийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх хүрээний асуудлын 1-р үр дүнг хэрэгжүүлэхтэй холбоотой Хөтөлбөрийн 1-р үр дүн. Хөтөлбөрийн үр дүнгийн дугаараар X үсгийн дараах тоо өөрчлөгдөнө.

Хоёр. Тухайн жилд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ:

Хүснэгт 5. Тухайн жилд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ

Код	Бодлогын үндэслэл	Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт				Шаардлагатай хөрөнгийн хэмжээ	Санхүүжилтийн эх үүсвэр									
			Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилгот түвшин		Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Гадаадын зээл	Гадаадын тусламж	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Тусгай сан	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр	Хариуцагч
Y1C1T1X1																	
Y1C1T1X1Гү1*																	
Y1C1T1X1Гт1**																	
Y1C1T1X1Га1***																	

Тайлбар: * Y1C1T1X1Гү1 – Хөтөлбөрийн 1-р үр дүнг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн үйл ажиллагаа 1. “Гү”-гийн дараах тоо нь үндсэн үйл ажиллагааны дугаарыг илэрхийлнэ.

** Y1C1T1X1Гт1 – Хөтөлбөрийн 1-р үр дүнгийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл 1. “Гт”-гийн дараах тоо нь төслийн дугаарыг илэрхийлнэ.

*** Y1C1T1X1Га1 – Хөтөлбөрийн 1-р үр дүнгийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ 1. “Га”-гийн дараах тоо нь арга хэмжээний дугаарыг илэрхийлнэ.

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/167 тушаалын гуравдугаар хавсралт

УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЦАГЛАВАР

Хүснэгт 1. Эдийн засаг, хөгжлийн яамны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах цаглавар

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах	Өмнөх оны 11 сарын 15-ны дотор
2	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулах нарийвчилсан төлөвлөгөөг батлуулах	Өмнөх оны 11 сарын 18-ны дотор
3	Энэ аргачлалын 4.1.1-4.1.7-д заасан өгөгдөл, мэдээллийг холбогдох талуудаас авах	Өмнөх оны 11 сарын 25-ны дотор
4	Нөхцөл байдлын урьдчилсан дүн шинжилгээ хийх	Өмнөх оны 12 сарын 01-ний дотор
5	Холбогдох байгууллагаас санал авах маягт, маягтыг бөглөх заавар (удирдамж)-ыг хүргүүлэх	Өмнөх оны 12 сарын 05-ны дотор
6	Шаардлагатай тохиолдолд холбогдох талуудад арга зүйн сургалт, зааварчилгаа өгөх	Өмнөх оны 12 сарын 15-ны дотор
7	Холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах санал авах	1 сарын 15-ны дотор
8	Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж дуусгах	2 сарын 01-ний дотор
9	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж дуусгах	2 сарын 20-ны дотор
10	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагад танилцуулж, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал авах	2 сарын 28-ны дотор
11	Холбогдох байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд өгсөн саналыг үндэслэлтэй тохиолдолд төсөлд тусгах	3 сарын 05-ны дотор
12	Төслийг сайдад танилцуулах	3 сарын 05-ны дотор
13	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд өгсөн саналын тусгагдсан байдал, үндэслэл, тайлбарыг санал ирүүлсэн байгууллагуудад мэдээлэх	3 сарын 15-ны дотор
14	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний Үзэл баримтлалын төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга боловсруулах	3 сарын 20-ны дотор
15	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Засгийн газарт танилцуулах	3 сарын 25-ны дотор
16	Ажлын хэсэг нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмж боловсруулж оролцогч талуудад нэгдсэн байдлаар хүргүүлэх	4 сарын 01-ний дотор

Хүснэгт 2. Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагын Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулах цаглавар

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа
1	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулах ажлын хэсэг байгуулах	Өмнөх оны 12 сарын 10-ны дотор

2	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулах нарийвчилсан төлөвлөгөөг батлуулах	Өмнөх оны 12 сарын 16-ны дотор
3	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх	Өмнөх оны 12 сарын 20-ны дотор
4	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс санал авах маяг, заавар (удирдамж)-ыг боловсруулж хүргүүлэх	Өмнөх оны 12 сарын 22-ны дотор
5	Шаардлагатай тохиолдолд холбогдох талуудад арга зүйн сургалт, зааварчилгаа өгөх	Өмнөх оны 12 сарын 25-ны дотор
6	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах санал авах	1 сарын 01-ний дотор
7	Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж дуусгах	1 сарын 05-ны дотор
8	Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн саналыг нэгтгэн боловсруулах	1 сарын 10-ны дотор
9	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг ЭЗХЯ-нд хүргүүлэх	1 сарын 15-ны дотор
10	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд санал өгөх	2 сарын 28-ны дотор
11	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг нэгтгэн боловсруулах хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайлан, цаашид анхаарах асуудал, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар санал, зөвлөмж боловсруулж холбогдох талуудад хүргүүлэх	3 сарын 05-ны дотор

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 19 дугаар сарын 22-ны өдрийн А/НБТ тушаалын тавдугаар хавсралт



ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ МАЯГТ

Код	Бодлогын үндэслэл	Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тусгасан санхүүжилтийн хэмжээ	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах санхүүжилтийн хэмжээ	Зөрүү	Үндэслэл, тайлбар	Санхүүжилтийн эх үүсвэр											
							Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Гадаадын зээл	Гадаадын тусламж	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Тусгай сан	Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр			
							Y1C1T1X1											
Y1C1T1X1Гy1																		
Y1C1T1X1Гт1																		
Y1C1T1X1Гa1																		

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн тушаалын зургаадугаар хавсралт А/167

**УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСЛИЙН ТАЛААР
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БОЛОН ХОЛБОГДОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГАД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ, САНАЛАВАХ МАЯГТ**

Хүснэгт 1. Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллагаас Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгуулахаар ирүүлсэн саналд хариу мэдээлэл хүргэх ажлын хүснэгт

Код	Үр дүн, Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Саналын тусгагдсан байдал			Үндэслэл, тайлбар
		Бүрэн тусгасан	Нэмэлт өөрчлөлттэйгөөр тусгасан*	Хассан	
Y1C1T1					
Y1C1T1X1					
Y1C1T1X1Гү1					
Y1C1T1X1Гт1					
Y1C1T1X1Га1					

* Саналын бүрдлийн аль хэсэгт ямар өөрчлөлт оруулсныг товч тодорхойлж бичнэ.

Хүснэгт 2. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд хариу мэдээлэл хүргэх ажлын хүснэгт

Код	Үр дүн, Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Ирүүлсэн санал	Саналын тусгагдсан байдал			Үндэслэл, тайлбар
			Бүрэн тусгасан	Нэмэлт өөрчлөлттэйгөөр тусгасан*	Тусгаагүй	
Y1C1T1						
Y1C1T1X1						
Y1C1T1X1Гү1						
Y1C1T1X1Гт1						
Y1C1T1X1Га1						

* Саналын бүрдлийн аль хэсэгт ямар өөрчлөлт оруулсныг товч тодорхойлж бичнэ.